

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн! АНХ ДУГААР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь
жилдээ

№ 62 (2326)

1974 оны 8 дугаар сарын 19

ДАВАА

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НЭГЖ ДЭХ НАМЫН АЖИЛ

Намын гишүүн А. Намжил ахлагчтай механикжсан бригад 550 тонн өвс хадаг. Коммунист Ц. Самбуу гар хадгуураар 3 тонн өвс хадаж, 450 кг дарш хийв. Н. Өлзийтөгтох ахлагчтай механикжсан салаа өдрийн нормоо 134—213 хувиар биелүүлэн бусдыгаа хошуучилж явна. Ийм олон мэдээ Өндөрширээтээс, Алтанбулагаас, Баянцогтоос, ер нь САА, ТАА, ХАА-н нэгдлүүдээс аймгийн Намын хороонд тасралтгүй ирсээр байна. Намын байгууллагуудаас коммунистуудын дунд зохиох ажлаа тууштай сайжруулбал цаг ямагт бүтээлч эрч хүч оргилсон, урам зориг бадрангуй, ажилч хичээнгүй байдал бий болж чаддаг билээ.

Чухамхүү үйлдвэрлэлийн нэгжид бүхний анхаарлыг татан өрнөж байгаа цаг үеийн ажлыг амжилттай хангахад манай коммунистуудын хамгийн шадар удирдагч намын хэсгүүд нэн их үүрэг гүйцэтгэх ёстой.

Ийм ч учраас үйлдвэр албан газрын цех, бригад, тасаг зэрэгт намын хэсэг байгуулан ажиллуулах нь намын хүчийг хуваарилах ажлыг сайжруулж, хамт олны ажилд намын ажлын нөлөөг тухайлбал тэдний ажиллаж байгаа салбарын үйл ажиллагаанд намаас тавих өдөр тутмын хяналтыг хүчтэй болгох ажлыг хэрэгжүүлэхэд тусладаг гэж НАШБ-ын нарийн бичгийн дарга нарын улсын зөвлөлгөөн цохон заасан билээ.

Одоо аймгийн хэмжээгээр намын 60 гаруй хэсэг үйлдвэрлэлийн нэгжид ажиллаж байна.

Аймгийн намын анхан шатны байгууллагууд нарийн бичгийн дарга нарын улсын зөвлөлгөөнөөс хойш үйлдвэр, барилга, тээвэр, холбоо зэрэг байгууллагуудын жинхэнэ үйлдвэрлэл явагддаг нэгжүүдэд намын олон хэсэг шинээр байгуулж, зохион байгуулагчдыг семинарлан ажиллуулж байна.

Үйлдвэрлэлийн нэгж дэх намын хэсгийн гол ажил нь коммунистуудыг

үйлдвэрлэлийн салбаруудад зөв байршуулан, манлайлыг өндөржүүлэхийн тулд тэдний ажилд байнга хяналт тавьж туслах, цех бригад, тасгийн хариуцлагатай, тэнд ажилладаг олон шийтийн байгууллагуудын үйл ажиллагааг улсын төлөвлөгөө биелүүлэх, хөдөлмөрийн хамт олныг хүмүүжүүлэхэд нэгтгэн чиглүүлэхэд оршино.

Мөн хамт олноос социалист уралдаанд авсан үүрэг амлалт хэрхэн биелж байгааг цаг ямагт анхаарлынхаа төвлөж байсан тэргүүний хүмүүсийг алдаршуулах, тэдний туршлагыг ийтийн хүртээл болгох, СХ-ийн хөдөлгөөнийг өрнүүлэх талаар цуцалтгүй ажиллаж байвал зохино.

Үйлдвэрлэлийн нэгж дэх намын ажлын нэг чухал хэсэг нь тодорхой ажил эрхэлж байгаа намын гишүүд, орлогч гишүүдтэй нэгбүрчлэн уулзаж, тэдний санал бодлыг сонсож, ажилд нь санаж зөвлөлтөө өгч, дутагдал доголдлыг нь засч байх явдал мөн.

Бригад, цех, тасгууд дахь намын хэсгийн ажил ямар байх нь намын анхан шатны хороо, үүрүүдээс тэдний ажлыг хэрхэн чиглүүлж, зааж тусалж байгаагаас ихээхэн шалтгаална.

Намын хэсгийн ажлыг тодорхой хугацаанд дүгнэх, илтгэл сонсголыг нь хэлэлцэх, хэсгийн ажлын толь болсон дэвтэр хөтлөлтийн байдлыг байн байн шалгаж зааварлах, богино хугацаанд гүйцэтгэх хүч хөдөлмөр ихээхэн шаардсан ажлын үеэр намын үүр, хэсэг байгуулан ажиллуулах зэргээр хэсгийн ажлыг цаг үргэлж тодорхой удирдаж байх хэрэгтэй.

МАХН-ын III их хурал хуралдсан, БНМАУ-ыг тунхагласны түүхт 50 жилийн ойг угтаж үйлдвэрлэлийн нэгж дэх намын хэсгийн ажлыг шинэ шатанд гарган, НАШБ-ын нарийн бичгийн дарга нарын улсын зөвлөлгөөн, аймгийн намын XVI бага хурлаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх явдал намын байгууллагуудын чухал зорилтын нэг мөн.

УРАЛДААН ДҮГНЭВ

Аймгийн Намын Хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа, ҮЭ-ийн Зөвлөл, ХЗЭ-ийн хорооноос хадлан тэжээл бэлтгэх ажилд тэргүүний амжилт гаргасан сум-нэгдэл, САА, хороо захиргаа, ТАА, ферм, бригадыг шалгаруулах болзолт уралдааныг саяхан дүгнэв. 1974 оны 8 дугаар сарын 10-ны байдлаар хадлан бэлтгэх төлөвлөгөөг болзолд заасан хэмжээнээс 4.0 хувиар давуулан биелүүлсэн Баян-Өнжүүл сумыг 1 дүгээр байр эзлүүлж, айм-

гийн Намын хороо, АДХ-гүйцэтгэх захиргаа, ҮЭ-ийн зөвлөл, ХЗЭ-ийн хорооны диплом, 350 төгрөг, төлөвлөгөөг 3.9 хувиар давуулж биелүүлсэн Өндөрширээт, мөн 1.2 хувиар давуулсан Жаргалант сумыг 2, 3 дугаар байр эзлүүлж аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа, ҮЭ-ийн зөвлөл, ХЗЭ-ийн хорооны баярын бичиг, мөнгөн шагналаар шагналаа.

МАНЛАЙ СУРВАЛЖЛАГЧ

Сонины нэрэмжит шагнал олгов

Саяхан аймгийн сонины редакци Алтанбулаг сумын Алтан-овдо бригадын Рэгзэн ахлагчтай залуучуудын хадлангийн бригадынхны дунд "Анхдугаар таван жил" сонины нэрэмжит өндөр бүтээлийн 3 хоногийн уралдаан зохион явуулж дүгнэв. Уралдаант 3 өдөрт тус бригад 80 гаруй тонн өвс хадаж бэлтгэжээ.

Уралдаанд сумын аварга хадланч, МАХН-ын гишүүн Ч. Цэрэндорж өдөр бүрийн нормоо 171,1—202,2 хувиар биелүүлж тэргүүн байр эзлэн сони-

ны нэрэмжит шагнал авав.

Мөн тармагч, МАХН-ийн гишүүн Г. Энхбат 178,8—200,7, хадлагч Д. Өрнөдэлгэр, Ц. Рэгзэн нар 122,7—198,3, бухалдагч Чулуун, Даваасамбуу нар 140—152,3 хувиар биелүүлж уралдаанд амжилттай оролцов.

Уралдаан дүгнэх үеэр аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга Ч. Дашдэмбэрэл тус бригадын хадланчдын ажилтай танилцаж зөвлөлтөө өгөв.

Л. ГУНГААБУУ

1974 оны ургац хураалтанд өндөр амжилт гаргасан САА, ТАА, ХАА-н нэгдэл, тэргүүний тракторч-колбайнчдыг шалгаруулан шагнах социалист уралдааны БОЛЗОЛ

МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жил, атар газар эзэмшсэний 15 жилийн түүхт ойнуудыг угтаж тус аймгийн ХАА-н байгууллага, тариаланч—механикчуудад нийт хөдөлмөрчдийн идэвх санаачлагыг өрнүүлэн, 1974 оны ургацын төлөвлөгөөг давуулан биелүүлэх зорилгоор аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа, ҮЭ-ийн Зөвлөл,

ХЗЭ-ийн хорооноос социалист уралдаан зарлаж байна.

Социалист уралдаанд шалгаруулах үзүүлэлтүүд:

1. САА, ТАА, ХАА-н НЭГДЛҮҮД.

а) 1974 оны хураан авах ба улсад тушаах үр тариа, төмс, хүнсний ногоо, малын таримал тэжээлийн төлөвлөгөөг төрөл тус бүр дээр 103-аас дээш хувиар биелүүлэх.

б) дараа жилийн хэрэгцээг үр тариа, төмс, малын тэжээлийн ургамлын үрийг хүрэлцэхээр нөөцлөж, цэвэрлэн халгалах.

в) улсад тушаасан үр тариа, төмс, хүнсний ногоо нь чанарын талаар стандартын шаардлагыг бүрэн хангасан байх.

г) тэжээлийн үйлдвэрт тушаах сүрэл, улсын фондод тушаах өвсний төлөвлөгөөг биелүүлэх.

д) урингийн төлөвлөгөөний дутууг цэвдэгшээр нөхөж, цэвдэгшийн төлөвлөгөөг биелүүлэх.

е) ургац хураалтын үед оюутан сурагчид, цэрэг, тээвэрчид, ажилчдын соёл ахуйн үйлчилгээг сайн хангаж үйлдвэрлэлтэй холбогдсон ооо аюул гаргаагүй байх.

(Төгсгөл нь II нүүрт)

Ж. Норжинцэрэн аймгийн Нэгдэл дундын үйлдвэрт слесарьчаар ажилладаг.

Тэрээр 57 насныхаа 36 жилийн тракторч колбайнчаас эхлэн механик, слесарьч, токарч хүртэл техникийн олон мэргэжлийг эзэмшин ажиллаж байгаа хүн.

Ж. Норжинцэрэн бүх ард түмний социалист уралдааны жил—1974 оны сар бүрийн төлөвлөгөөг 20—50 хувиар давуулан биелүүлж байна.

ЗУРАГ ДЭЭР:

Слесарьч Ж. Норжинцэрэн моторын засвар хийж байгаа нь.

III. ЦЭРЭНДОО-гийн авсан гэрэл зураг.



•ӨВС ХАДЛАН.

•ӨН ТАРГА.

УЛАМ ШАМДАХ ЦАГ

Малдаа арвин их өвс хадлан бэлтгэх ажил газар сайгүй өрнөж байна.

Лүн сум энэ жил 4200 тонн өвс бэлтгэх төлөвлөгөөтэйгээр хадлангийн бригад 5-ыг гарган ажиллуулж, одоогийн байдлаар 1500 тонн өвс бэлтгээд байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс ахицтай байна. Сумын нам, захиргаа, олон нийтийн байгууллагаас хадланчдын дунд уралдааны болзол гаргаж, хүмүүсийн өдөр тутмын ажлыг цуваагаар байр эзлүүлэн дүгнэж, бригад, салааны хоорондын уралдааныг 3, 5 хоног тутам дүгнэн шагнаж урамшуулж байгаа нь хүмүүсийн хөдөлмөрлөх сонирхлыг ихэд өрнүүлжээ.

Мөн өрх бүрт 4 кг өвс, хүн бүрт 20-25 кг аги түүүж бэлтгэх даалгавар өгөөд ажиллуулж байна.

Саяхан хадланчдын уралдааныг дүгнэхэд «Цагаан уул» бригадын хадланч Нэргүй, Өгөөмөр бригадын Маам нар тэргүүн байранд оржээ. Трактор хадлуурч Нэргүй нийт хадлуурчдыг хошуучилж өдөр бүрийн төлөвлөгөөг 100-150 хувиар биелүүлж техникийн сааталгүй ажиллан өглөө ажилд гарахын өмнөх бэлтгэлийг урд орой нь ажлаас буусны дараа хийдгээс сааталгүй ажиллаж чаддаг ажээ. БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Шаравдорж ахлагчтай тус сум

мын механикжсан салаа сумын бүх төлөвлөгөөт өвсний тэн хагасаас илүү хувийг авахаар ажиллаж байна. Газрын гарц нь муугүй атлаа ургац шингэн, га-гаас 6-7 центнер унацтай байгаа нь чамлалттай боловч техникийн хүчийг бүрэн дүүрэн ашиглаж сааталгүй ажиллавал төлөвлөгөөг 9 дүгээр сарын 1 гэхэд биелүүлэх боломж байна. Энэ жил 4700 тонн хадлан бэлтгэх төлөвлөгөөтэй Заамар суманд хадлангийн ажлын явц ахицтай байна.

Сумын хэмжээгээр техникийн бригад 1, салаа 2-ыг Цавын даваа, Нумт, Мануулт зэрэг газар гарган ажиллуулж амжилт олж байна. Энэ сумын хадланчид га-гаас 6-7 центнер ургац авч одоогийн байдлаар 1800 тонн өвс хадаад байна.

Бригад салаандын хооронд зарласан сүүлийн 3 хоногийн уралдаанд хадлуурч Балдандорж, Дашдорж, Рагчаа, Жадамбаа, хамаан боогч Наранхүү, Лхагва нар 3 өдөрт 4 өдрийн ажил гүйцэтгэж уралдааны түрүүг хадгалсаар байна.

Гэтэл Цавын даваанд байгаа Аюуш даргатай механикжсан салаанд дээр техникийн саатлаас болж хадаад тармалгүй орхисон өвс их хэмжээтэй байгаа нь өвс хатаж шарлахад хүрч байна.

Гар тэжээл бэлтгэх

ажилд Ухаа бригадын 10 гаруй суурийн малчид 200, сумын төвийн хөдөлмөрчид 600 гаруй ширхэг мушгина хийж хошуучилж явна. Баянцогтын САА-и хэмжээгээр хадлангийн 2 механикжсан салаа 4600 тонн өвс бэлтгэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Тус САА-д хадлангийн салааг хооронд нь халз уралдаантай аж иллуулж салааг өдөр бүр, САА 7 хоног тутам уралдаанаа дүгнэж байна.

Хадланчдын уралдааныг дүгнэхдээ өдрийн аварга шалгаруулан, хөлөгт самбарт зургийг нь тавих, ҮЭ-ийн туг дээр түрүүлэх бүрт нь таван хошуу зурах, хадланчдын дунд 5 өдөрт 6 өдрийн ажил хийх, урьд өдөр нь төлөвлөгөө нөрмөө таслав дараа өдөр нь заавал нөхөж гүйцээж гэсэн хөдөлгөөн өрнүүлэн ажиллаж байгаа нь үр дүнтэй ажил болжээ.

Уралдаанд урам зориг нь бадарсан Түвдэнсүрэн, Өлзийтогтох ахлагчтай 2 салааныхны ажил жигд сайн явагдаж техникийн саатал нэгч удаа гараагүй уралдаанд зуузыг холбон уралдаж байгаагийн дотор хадлуурчдын аварга хадланч Өлзийтогтох, хадлуурч Цэрэнпил, пресслэгч Баасанхүү, хамаан боогч Базаррагчаа нар өдөр бүрийн төлөвлөгөөг 105-212 хувиар биелүүлж хамт олноо хошуучилж явна.

Сум САА-и хэмжээгээр 1200 гаруй хүнд 242 тонн өвс, 68 тонн витаминт

1974 оны ургац хураалтанд өндөр амжилт гаргасан САА, ТАА, ХАА-и нэгдэл, тэргүүний тракторч-комбайнчдыг шалгаруулан шагнах социалист уралдааны БОЛЗОЛ

Төгсгөл. (Түрүүч нь 1 нүүрт)

2. ТРАКТОРЧ—КОМБАЙНЧИД

а) комбайнчид ургац хураалтын хугацаанд 8,0 мянгаас доошгүй центнер үр тариа цайруулах.

б) тракторчид ургац хураалтын эхний 10 хоногт төмсний комбайнаар 25 га, даршны комбайнаар 80-аас доошгүй га талбайн ургац хурааж, авах ургачын төлөвлөгөөг 105-аас дээш хувиар биелүүлсэн байх.

в) ургац хураалтын үед техникийн ба үйлдвэрлэлийн осол аюул гаргахгүй ажиллах.

г) 1974 оны социалист уралдаанд авсан амлалт ба трактор, комбайнаар хийх ажлын жилийн нормыг давуулан биелүүлсэн байх.

д) тариалалт, ургац хураалт, уринш хагалгаа болон техникээр гүйцэт-

гэсэн ажлын 90-ээс дээш хувь нь чанарын онц байсан үнэлгээ авсан байх.

3 БОЛЗЛЫГ ДҮГНЭХ ЖУРАМ, ХУГАЦАА, ОЛГОХ ШАГНАЛ

а) Социалист уралдаанд САА, ТАА, ХАА-и нэгдэл гуравыг шалгаруулж тус бүрийг атар газар эзэмшсэний 15 жилийн ойн нэрэмжит дурсгалын диплом, 10,000 хүртэл төгрөгөөр шагнана.

б) тракторч комбайнч 20 хүнийг уралдаанд шалгаруулж, баярын бичиг мөнгөн шагналаар шагнана.

в) болзлыг ургац хураалтын эцэст дүгнэнэ.

г) социалист уралдаанд шалгаруулах байгууллага, хүмүүсийн тодорхойлолтыг аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны ХА АУ газраас гаргасан маягтын дагуу гаргаж ирүүлнэ.

АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГАА ХЭЭ-НИЙН ХОРОО

АЙМГИЙН НАМЫН ХОРОО, ҮЭ-НИЙН ЗӨВЛӨЛ

тэжээл бэлтгэх даалгавар өгсний дотор сумын төвийн 250 гаруй хүн 5 удаа субботник хийж механикжсан салаануудад туслажээ.

Одоогийн байдлаар 3700 гаруй га газар хадаж төлөвлөгөөт өвсний 50-иад хувийг бэлтгээд байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад давуу байна.

Малдаа арвин их өвс хадлан бэлтгэх ажилд олж буй амжилтаа улам бататган техникийн хүчин чадлыг бүрэн дүүрэн ашиглан, хадлан бэлтгэлийг тариа ногоо хураах ажилтай давхцуулаж бусад хугацаанд амжуулах нь дээрх 3 сумын чухал зорилт болж байна.

Л. ГУНГААБУУ

АЖЛЫН ХУВЬ ЗАЯА ХҮМҮҮСИЙН ХАРИУЦЛАГААС ШАЛТГААЛНА

Манай орны социалист бүтээн байгуулалтын хүрээ далайц өргөжин шийдвэрлэх асуудал нутгийн төлөөтэй болох тутам ажлын хариуцлага, тавигдах шаардлага улам өссөөр байна.

Нөхөр Ю. Цэдэнбал МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал дээр хэлэхдээ: «Социалист байгуулалтыг удирдах ажлыг үндсээр нь сайжруулахын тулд даалгасан ажлыг хийх талаар манай боловсон хүчний хувийн хариуцлагыг тууштай дээшлүүлэх явдал чухал юм.

Зохихон байгуулалтгүй, эмх замбараагүй, санаа амарлингүйн улмаас манай ажилд олон ноцтой дутагдал оршиж байна.

Иймд нам, улс, олон нийтийн байгууллагын бүх салаа мөчирт боловсон хүчинд тавих шаардлагыг дээшлүүлж даалгасан ажлыг хэрхэн биелүүлж байгааг сайтар хянаж байх явдал хэрэгтэй байна» гэсэн билээ. Хаана ажлын хариуцлага сахилга бат, хяналт шалгалт сайн

байна тэнд ажлын амжилт гарч, улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилт хугацаандаа тоо чанар, нэр төрлөөр давж биелэгдэж байдгийг Жаргалант, Борнуур, Батсүмбэр, Эрдэнэсант, Өндөрширээт сум, САА, нэгдэл, аймгийн Замын анги, Хүнсний үйлдвэрийн хамт олны амжилтын туршлага нотлон харуулж байна.

Гэтэл улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөгөөр оногдсон үүрэг даалгаврыг биелүүлэхгүй сум, хороо, үйлдвэр аж ахуйн газрууд цөөнгүй байна.

Ийм байдал зарчмын дүгнэлт хийх нь манай нам, улс, олон нийтийн байгууллагын өмнө чухал тавигдах байна.

Одоо аймгийн хэмжээгээр үр тариа хураах цаг ойртоод байхад комбайны засвар тариа хураалтын бэлтгэл ажил зарим газар хангалтгүй байна.

Угтаалын САА-и Н. Пүрэвсүрэн даргатай «Хар чулуутын тасаг 32 комбайн засахаас дөнгөж 20 хувийг засч, сэлбэг хэ-

рэгслээр дутагдаж байна. Ийм дутагдал мөн, Жаргалант, Батсүмбэрийн САА-нуудад үзэгдэж байна. Ийнхүү ажил жигд биш байгаагийн гол шалтгаан нь тэнд ажиллаж байгаа боловсон хүчин удирдах амжилтын ажлын хариуцлага, арга барил харилцан адилгүй байгаатай холбоотой юм.

Нам, улсын боловсон хүчний ажлын хариуцлагын тухай асуудал бол юуны өмнө нам, улсаас хүлээлгэсэн итгэл найдвар, түүний төлөө хүлээх хариуцлага бүрэн ухамсарлан, нам, улсын сахилгын шаардлагыг эрхэмлэн биелүүлэх, ажлын арга барилдаа байнга боловсонгүй болгох, мэдлэг боловсролоо цуцалтгүй дээшлүүлэх, ажил хэрэгч дайчин чанарыг тууштай эзэмших, асуудалд зарчимч бөгөөд шүүмжлэлтэй хандах, дутагдалтай өвлөршгүй байх зэрэг олон чухал зүйл хамаарагдана.

Манай нийт ажлыг сайжруулах гол голлоо асуудлын нэг ажилтан- бүрийн

хувийн хариуцлагыг дээшлүүлэх, хүн бүрийг эрхэлсэн ажилдаа бүрэн эзэн болж, гүйцэтгэх үүргээ яв цав биелүүлж түүнийг ямарч нөхцөлд хариуцаж чаддаг болгох явдал юм.

Ажлын дутагдал, тасалдал бүрийн шалтгааныг задлан шинжилж тэр нь ажил хариуцсан хүний мэдлэг мэргэжил хүрэлцэхгүйгээс болж ууссвал мэдсээр атлаа хийгээгүйгээс үү гэдгийг сайтар нягтлан тогтоож байх нь боловсон хүчний ажлын хариуцлагыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Улсын төлөвлөгөө таслаж, нам, улсаас өгсөн даалгаврыг биелүүлээгүй явдлаа өөрөөсөө үл шалтгаалах зүйл мэтээр тайлбарлаж хувийн хариуцлагаас зайлсхийх гэсэн оролдлого удирдах хүмүүс, боловсон хүчинд байж таарахгүй Ажилтан бүрийн хувийн хариуцлагыг жигд дээшлүүлэх нь хөдөлмөрийн хамт олон байгууллагын өмнө та-

вигдсан зорилтыг амжилттай биелүүлэхэд чухал хүчин зүйл болно.

Манай нам боловсон хүчнээ үнэлэн хүндэтгэж чухал албан тушаалд тавьж хариуцлагатай үүрэг даалгавар өгдөг.

Ажилтны ажлын хариуцлагыг дээшлүүлэх нэг чухам хэрэгсэл бол үйлдвэрлэл, хамт олны дотор хүн бүрийн гүйцэтгэх үүргийг нарийн тогтоож, хүн бүрийг хэвийн бөгөөд дүүрэн ажилтай байлгах явдал юм.

Үүний тулд тухайн аппаратын ажилтны ажлын хуваарь, хүн бүрийн ачааллыг сайн шалгаж тэдний хийх ажил гүйцэтгэх үүргийг яв цав тодорхойлон ажлын гүйцэтгэл, цаг ашигдалтын байдалд хяналт тавьж ажилтнуудын тайланг сонсч тэдний бүтээлийг ажлын жинхэнэ гүйцэтгэлээр нь дүгнэж ажил хэрэгч нөхөрсөг шаардлага тавьж байх нь боловсон хүчний өсөлтөнд болон хариуцлагыг дээшлүүлэхэд чухал нөлөөтэй юм.

Д. ДУЛАМЖАВ

Малын зүй бүсийн ХОРОГДОЛТОЙ ТЭМЦЬЕ

Тус аймгийн нилээд суманд бэлтгэлд мал тушаах, хүнсэнд мал нийлэхэд эдийн засгийн тооцоо үндэслэл муутай хандсан, мал үржүүлгийг замбараагүй явуулсан зэргээс шалтгаалж таван төрлийн малын зохистой харьцаа алдагдах, зарим төрлийн малын толгойн тоо ашиг шим буурахад хүрсэн зохисгүй байдал гарч байна.

Ялангуяа аймгийн хэмжээгээр адуун сүргийн тоо ихээр хорогдож ашиг шим нь алдагдаж байна.

Тухайлбал 10 жилийн өмнөх 3 жилийн дундаж буюу 1962—1964 оны дундажтай 1971—73 оны дундажийг харьцуулж үзэхэд 12800 толгойгоор буюу 44,1 хувиар буурч нийт адууны хорогдол 2,6 хувиар нэмэгджээ.

Зөвхөн 1962—1973 онд гүүний тоо 46,6 мянгаас 21,9 мянга хүртэл буюу хоёр дахингаас илүү хэм-

жээгээр цөөрчээ.

Үүнээс дүгнэлт хийж үзэхэд адуун сүрэгт онц анхаарал тавьж түүний хариуллага малаагаар сайжруулах, хээлтэгч малын тоог зохистой хэмжээнд хүргэх, үржлийн ажлыг зохион явуулах зэрэгт туршлагатай малчдын олон жилийн практик ажиглалтаар тодрон гарсан доорхи хэд хэдэн зүйлийг анхаарч ажиглах нь чухал юм.

Үүнд хариуллага малла-гаанд адууг хоньчилон хариулах явдал олон талын шалтгаанаар чухал зорилт болж байна.

Адууг цас шуургатай үед алсын нөмөртэй та-виухан нутагт маллах хэрэгтэй гадна цас шуур-ганд давчим газар хор-гоовол адуу шээж ам-жилгүй хорддог, хөдөл-гөөнгүй байлгаснаас ос-годог байна.

Их цастай бэлчээрт адууг зам дагуулан ор-

АДУУН СҮРГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАЯ

хивол түүнийг дагаж цу-ваад алдагдах, хоолгүй явсаар өлдөж турахад хүрдэг аж.

Өвлийн хүйтэн шөнө адуу цэнхэр цантай, дөр-вөн туурайдаа цасан товх той болоод үүрээр их даарч бөөн хоносноо гэр-гээ үзээд тардаг.

Энэ үед нь тараалгүй цуглуулаад нар эрт ту-сах бараан газар тогтоох нь зүйтэй.

Ингэхэд адуу туурны цасан товхоо унагаж хөр-вөн цангаа гөвөөд дулаа-цаж унтдаг учир даарч турдаггүй. Зуны улиралд адууны хариуллага малла-гаар сайжруулж ялангу-яа саалинд саагдаж бай-гаа гүү унаганд сайн ан-хаарал тавьж хужир ус тэгшхэн нутагт байлгаж ойр ойрхон нутаг сэлтэх нь ашигтайн гадна гүүг эрт саалинаас чөлөөлж адууг нийтэд нь сөл ган-даагүй байхад оторт гар-гаа нь авсан тарга хүтээ өвлийн цагт хадгалж тог-тооход сайнаар нөлөөл-дөг. Улсын болон төвлөр-сөн хэрэгцээнд мал бэлт-гэхдээ гүүг олноор тушаах өвлийн идшинд махны

амтлаг зөөлнийг харж нийлэх явдал үзэгдсээр байгааг зогсоож нэгдэл САА бүр адууны хээлтэгч малын зохистой харь-цаанд судалгаа хийж ой-рын үед хээлтэгчийн тоог тохирох хэмжээнд хүртэл өсгөх ажлыг төлөвлөн хэ-рэгжүүлэх нь зүйтэй юм.

Адууны үржлийн ажилд муугаар нөлөөлж байгаа зүйлүүд болох адуу олон зуу гаар сууриж хариулла-гагүй зэлүүд бэлчээрлүүд гээс хээлтүүлэг хангалт-гүй явагдаж, хээр гарсан унага чононд идэгдэх эл-дэв шалтгаанаар хорог-дох явдал их байна.

Адууг азарга азаргаар нь салгаж хариулах нь гүүний ороо оролт, хээл авалтыг хянаж ажиллах бололцоог олгоно.

Азарга удам төрлөө хурааж гишгэж хээлтүүл-дэггүй, байдсан гүү дан-гаараа байвал ороо нь ордоггүй онцлогийг адуу-чин бүр мэдэж байдсыг бүдүүн гүүний хамт байл-гаж ороогий нь оруулах гүүг удам төрлийн бус азарганд хураалган гиш-гүүлж хээлтүүлбэл зохи-но. Хээлтэй гүүг хөлөр-

гөж халаагаад усалбал хээл хаялгаас сэргийлж маргааш услахын тулд шөнийн бэлчээрээр усан-даа ойртуулан хоноод ха-лааж цантаалгүй услах нь зүйтэй. Гүү унагалмагц эхий нь хамт 7—14 хоно-гоор тусгай байр хашаанд тэжээж байх нь ашигтай.

Ингэж тэжээхдээ өдөр бүр унагыг эхтэй нь хамт байрцаас гаргаж 7—8 ца-гийн турш ойр зуур бэлч-ээж маллавал унаганы бойжилт түргэсдэг.

Гүү унагалмагц гурилыг ялимгүй элс, устай хольж шингэн жонхуу хийгээд унаганы зоонд нь жигд түрхвэл бороо цасны ус унаганы үсэнд нэвтэрч тогтохгүй унаганы үс сал-хинд ярагдан хийсч даар-даггүй сайн талтай.

Жишээ нь 500 унага жонхуудахад 20 кг орчим гурил орно.

Өдөрт цөөвтөр гүү унагалдаг учир адуучид туршин үзэж болох юм.

Энэ мэт арга ажиллагаа нуудыг адуучин бүр мэдэж ажиллавал адууны тогт-вортой өсөлтийг ханга-хад зохих ёсоор нөлөөлнө. Х. СОДНОМДАРЖАА

Отрын тарга-оны хүч

ТАРГАН САЙХАН ЗУСЧ БАЙНА

Баруун баян, Оргиоч, Гичигний гол, Сэршиг гээд зуншлага сайхан уул толгодын бэл хор-мойгоор малчны цагаан гэрүүд ярайн үзэгдэнэ.


Үзэсгэлэнт Гичигний голын хөвөөгөөр Эрдэнэ-сант сумын «Саруул-амьд-рал» нэгдлийн «Угалзат» бригадын оторчид тарган сайхан зусч байна.

Сэршиг хэмээх уулын хормойгоор улаан голдуу үхэр сүргээ тогтуухан хариулж яваа аймаг су-мын 8 удаагийн аварга энх сүрэгтэн Дорж гуай-тай уулзлаа.

Тэрээр өнөө жил зунш-лага сайхан болохоор үхэр таргалж өнгө зүс-тэй байна.

Манайх хавраас эхлэн одоо хүртэл 8 дахь удаа-гаа Баруун баян, Оргиоч, Гичигний гол гээд өвс ургамал ус хужир жигдхэн нутгаар отор нүүдэл хийсээр үхэр сүр-гээ таргалуулж байна гэж ярилаа.

Дорж гуай 1957 онд нутгийн хэдэн өрхөйл са-наа нийлж Эрдэнэсант сумын «Жаргалант» хэм-ээх нэгдлийг байгуула-хад тулгын чулууг нь тулалцсан ахмад малчны нэг юм.



Тэрээр эдүгээ 18 жил үхэр сүрэг хариуцсан туршлагатай үхэрчин.

—Би голдуу нэг насны үхэр авч 2—3 жил мал-лаад дундаас дээш тар-га хүчтэй тушааж үйлд-вэрлэлийнхээ даалгаврыг давуулан биелүүлж ир-лээ. 1960—1965 онд ха-риуцан малласан бэлтгэ-лийн насны 500 гаруй хя-зааланг тушаахад эр үхэр дунджаар 240—250 кг жинд хүрвэ.

Үхэр сүргийнхээ ашиг-шнимийг нэмэгдүүлэх та-лаар 1980 он хүртэл ут-вар төлөвлөгөөтэй ажил-лаж байна.

Манайх 210 гунжин үнээг онд мэнд оруулж 200 үнээ саалинд шил-жүүлээд одоо 217 үнээгээ тарга хүч авахуулахаар алсын отор нүүдэл хийж явна. Ер нь 1963 оноос эх-лэн охин баяруу маллаж 5 жилд 735 үнээг саалинд шилжүүлсэн юм.

Би үхэр сүргийг хонь-чилон малладаг.

Үхрээ өглөө эрт бэлч-ээж, өвс ургамлын сах-

лагийг даган хариулдаг. «Ар буурал» гэдэг газар манай өвөлжөө бий.

Өвөлжөөндөө 40 метр урт, 8 метр өргөн саравч тай тохилог хашаа барьж мөн худаг гаргасан.

Сууриараа 20—30 тонн өвс хадаж өвөлжөөндөө татаж авдаг.

Өнөө жил 20-оос доош гүй тонн өвс хадаж ава-хаар өвөлжөөнийхөө ой-ролцоо өглөө оройд хад-лан хадаж байна.

Хүйтний улиралд үхэрт хамгийн гол нь дэвсгэр бууц дулаахан тохилог хашаа саравч чухал. Өв-лийн улиралд үхрийг уулын өвөр бэл нам дор, алсын жавар хүйтэн орох гүй газар хариулж өдөрт хоёр удаа услан өнжөөд хужирлаж байх нь сайн.

Хаврын улиралд таа-ваар нь өвс ургамлын шинийг дагуулан маллаж хялгана, улаан устай, ширэг идүүлэх нь илүү ашигтай. Зун уужим бэлч-ээрт малладаг. Цэцэг навч, шар цэцэгтэй харга-ланд үхэр маш дуртай байдаг.

Намар сөлхөөлдөн, өөхөн тарга авахуулахад их анхаардаг гэж Дорж ялив.

Н. НАНЖИД



Аймгийн Ойн аж ахуйн модон эдлэлийн төвийн тасгийн мужаан Р. Жамьяншарав энэ оны 7 дугаар сарын төлөвлөгөөг 114,6 хувиар биелүүлж социалист уралдаанд нөхдөө хошуучлан ажиллаж байна.

Ш. ЦЭРЭНДОО-гийн авсан гэрэл зураг.

БҮТЭЭЛЧ ТӨЛӨВЛӨГӨӨ-ҮР ДҮН

Бүтээлч ажлын тө-лөвлөгөө зохиож ажил-лах санаачлага тус айм-гийн мэргэжлийн сэхээт-нүүдийн дунд орнож байна. Энд Алтанбулаг сумын үйлдвэр-туршлага станцын зоотехникч Адьяасүрэнгийн бүтээлч төлөвлөгөөний үр дүн-гээс нийтлэв.

үнээний суурийг хариуцан авч ажилласан юм.

Тэрээр хар тарлан үнээ-ний суурьт ирж ажиллаад үнээ бухны арчилгаа мал-лагаар сайжруулан, малч-дад мэргэжлийн зөвлөл-гөө өгч, зун цагийн хү-мүүжлийн ажлыг тогтмол-жуулсны дээр үнээ төл-лөлт, тугал бойжилт, зо-хиомол хээлтүүлэг, хя-налтын саамын зэрэг аж-луудад анхан шатны бүрт гэдүлдийг нарийн хөтөлж ажилласны үрээр тус суурийн үнээний 90 ша-хам хувь нь хээлтүүлэгт орж хээл авбал зохих бүх үнээний 79 хувь хээл аваад байна.

Ш. ДИНАМ

НОМЫН ЕРТӨНЦӨД

ЗХУ минут тутамд 3 мянга орчим, өдөрт дунд-жаар 4 сая ном хэвлэж байна.

Эдүгээ ЗХУ-д 200 га-руй хэвлэлийн газар га-даадын 56, Зөвлөлтийн 89,

бүгд 145 хэл дээр ном хэвлэж байгаа аж.

Юнеско-гийн мэдээгээр Зөвлөлтөд гадаадын 101 орны зохиолчдын бүт-ээл хэвлэгдсэний дотор социалист орны 1200, Францын 522, Английн

316, АНУ-ын 325, Ази, Африкийн 500 орчим, Скандиновын орнуудын 150 бүтээл тус тус ор-сон байна.

ЗХУ-д жилдээ хэвлэ-лж байгаа номын гурав-ны нэг хувь нь уран зо-хиолын ном юм.

ТАЙЛАН БАЛАНСЫН ГАРГАЛТ

Тайлан-балансыг хугацаанд нь үнэн зөв гаргах нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд судалгаа хийж цаашид ажиллах арга замыг зааж өгөхөд үндсэн материал нь болдог.

Манай аймгийн үйлдвэр аж ахуй, төсөвт албан газруудын тайлан-балансын гаргалтын хугацаа богиносч чанар нь сайжирч байна. Аймгийн Харилцаа холбоо, Барилга угсралтын контор, Хөвлөх үйлдвэр, Алтанбулагийн үйлдвэр туршлагын станц, Заамарын техник мэргэжлийн сургууль, Соёлын хэлтсийн тайлан-баланс тогтмол 3—20 хоногийн өмнө гардаг бо-

лов. Дээрхи газрууд баримт эргэлтийн төлөвлөгөөг нарийн баримталж, богино хугацаанд боловсруулж байгаагийн дээр нягтлан бодогчдын ажлын хуваарь сайжирч зохих үр дүнд хүрчээ. Түүнчлэн анхан шатны бүртгэлийг бүрэн нэвтрүүлэхийн тулд тасаг, цехийн бүртгэлийг хангын самбараар дүгнэж хамт олонд сурталчлах ажлыг Харилцаа холбоо, Эрүүлийг хамгаалах газарт сайн хийсэн нь тайлангийн үзүүлэлтүүд үнэн зөв гаргах нэг нөхцөл болжээ.

Гэвч НААУ-ийн газар, Ойн аж ахуй, Ардын боловсролын хэлтэс зэрэг байгууллагат тайлан ба-

лансын гаргалтын хугацаа удааширч тайлангийн дотоод үзүүлэлтүүдийн уялдаа холбоо буруу гарах явдал ч байна.

Үйлдвэр аж ахуйн газар, төсөвт албан газруудад баримт эргэлтийн төлөвлөгөөг нарийвчлан гаргаж холбогдох хүмүүст танилцуулж биелэлтийг дүгнэж ажиллах нь тайлан-баланс хугацаандаа гарах үндэс гэдгийг анхаарах хэрэгтэй юм. Нөгөө талаар баримтын боловсруулалтыг нягтлан бодогчид богино хугацаанд хийж сарын тайлан-балансыг гаргаж ажиллах шаардлагатай.

Сарын тайлан-балансанд тулгуурлан эдийн засаг-

чид дүн шинжилгээ хийж байх ёстой. Нягтлан бодогчид тайлан-балансын бүхий л үзүүлэлтүүдийн хоорондын уялдаа холбоог шалгахын дээр үйлдвэр аж ахуйн газрын дарга, эрхлэгчид түүнтэй нарийн танилцаж шалгах нь зүйтэй юм. Тайлан-балансыг холбогдох байгууллагуудад тушаахдаа журнал ордер, туслах, тодотгох, ерөнхий дэвтэр зэрэгийг авч ирэхийн гадна төсөвт албан газрууд төлөвлөгөөний гүйцэтгэлтэй холбогдуулж санхүүжилтын тооцоог хийсэн байх нь чухал.

Ер нь тайлан-баланс гаргах бэлтгэл ажлыг төлөвлөгөөтэй зохион байгуулж, юуны урьд тооцоо бодох, тооллого явуулах, тооцоо нийлэх ажлуудыг

богино хугацаанд хийх хэрэгтэй. Тайлан-балансанд хавсралт илтгэх хуудсыг БНМАУ-ын Сангийн Яамнаас баталж гаргасан зааврыг мөрдлөг болгон бичиж, үйл ажиллагаа бүхэнд дүгнэлт өгсөн байвал зохино. Тайлан-балансын гаргалтанд нийт хүмүүсийн анхаарлыг хандуулж холбогдох баримт материалыг хариуцагч хүмүүс богино хугацаанд гаргаж байх нь зүйтэй.

Тайлангийн эцсийн үр дүнг хамт олны хурал зөвлөлгөөнөөр хэлэлцэж тэдний санал хүсэлтийг сонсож ажилдаа тусгаж ажиллах явдал тайлан-балансын эдийн засгийн үзүүлэлтүүдийн чанар дээшлэх нэг нөхцөл болдогийг анхаарвал зохино. Д. ТӨМӨР

ТОВЧХОН

«Өндөрширээт сумын улсын аварга хадланчин Чойжилсүрэн даргатай Наранбилэг бригадын хадланчид 850 тонн өвс хадах төлөвлөгөөг 9 дүгээр сарын 1-нд 105 хувиар биелүүлэх амлалт авч ажиллаад одоогийн байдлаар 400 гаруй тонн өвс хадаад байна.

Тус бригадын хадланчин улсын аварга Н. Болд 885 тонн өвс трактор хадгуураар 9 дүгээр сарын 1-ний дотор хадах үүрэг авч өдөр бүрийн нормоо 120—140 хувиар биелүүлэн хадланчдаа хошуучилж явна.

Саяхан дүгнэсэн уралдаанд тармагч Галаа, Бямцогт, нуруулдагч Чүлтэм, Жигжид, Д. Ширмэнтүяа, бухалдагч Нямжав, Болдбаатар, Буяцогт, Ганболд, бухал чирэгч Энхтайван, Батбаяр нар өдөр бүрийн төлөвлөгөөг 20—30 хувиар давуулан түрүүлэв.

«Батсүмбэрийн САА»-н Сөгнөгөрийн голын Д. Пүрэв даргатай ногоо бригадынхан манжин, лууван, байцаа улсад тушаах төлөвлөгөөг 150-200 хувь биелүүлэх зорилт тавин ногооны зэрлэгийг Зудаа цэвэрлэж, түүнээсээ эрт ургатан ногоо хурааж байна.

ЭМЧИЙН ЗӨВЛӨЛГӨӨ

АСРАМЖ ЧУХАЛ

Нялхсыг муу асрамжилснаас уушигны хатгалгаа, хордлогот биж зэрэг өвчнөөр өвчилж уул өвчин хүндэрч, эндэх явдал тохиолддог.

Нялхсын асрамжинд орон байрны эрүүл ахуй, хооллуулалт, асаргааны хоногийн нарийн дэглэмийг чанд баримтлах нь чухал. Нярай үе буюу төрсний дараах 28 хоногт онцгой асрамж шаардлагатай. Хүүхэд эхээс төрмөгцөө гадна орчинтойгоо зохицож эхэлдэг.

Нярай хүүхэд хоногт дунджаар 7-14 удаа шингэнээр, 2-6 удаа өтгөнөөр бие засах учир олон удаа хуурайлах шаардлагатай. Өтгөнөөр бие зассан даруйд бөгсийг буцалгасан усаар угааж, зөөлөн даавуу алчуураар дарж арчина. Харин хүүхдийн сарын тоо нэмэгдэх тутам өтгөн шингэний тоо цөөрнө.

Асрамж муу ай хүүхдийн биеийн жин нэмэгдэхгүй суга, цавины нимгэн хэсэг нуруж улайх, бөгс нь осгортож шалбарах байдлууд ажиглагдана. Энэ нь цаашдаа арьсны идэвт үрэвсэл болж хүндэрдэг.

Нялх хүүхэд хоногийн

ихэнх хугацааг тайван нойрсож өнгөрөөнө. Зарим хүүхэд асрамж сайтай атлаа үргэлжлэн уйлах явдал ажиглагддаг.


Энэ үед хүүхэд хөхөндөө цадахгүй байх, эсвэл ямар нэгэн эмгэг өвчний илрэл байж болох учир эмчийн зөвлөлгөөг цаг алдалгүй авах нь зүйтэй.

Нялхсыг нар агаар тутмаг, чийгтэй тохиромжгүй байранд асарснаас сульдаа өвчтэй болж уурлаж уцаарлах, хөдрөх, биеийн осолт удааширч зэрэг анхны шинжүүд илэрдэг.

Иймд салхиныхаа нээж гэр орондоо цэвэр агаар оруулж байх, дулааны улиралд бол нялхсыг 10-15 минутад нар салхинд гаргах зэргээр асарч байх нь чухал.

Нялхсыг төрсний дараагаар хөхнөөс нь гаргаж тэжээвэр болгох, өгөх сүүний найрлага хэмжээ, дэглэмийг нарийн баримтлахгүй бол тураалд оруулдгийн санах нь чухал. Сульдаа тураалтай хүүхэд амархан өвчилж биеийн эсэргүүцэл нь эрс сулардаг. Ийм хүүхдийн асрамжинд илүү анхаарах нь чухал байдаг.

Хүүхдийн их эмч
М. ГҮРСЭД



Москва дахь Цирк-эстрадын урлагийн дунд сургууль байгуулагдсаны 50 жилийн ой болж байна. Тус сургуулийг Карандаш (М. Румянцев), Олег Попов, Леонид Енгисбаров, Андрей Николаев, Нина Логачева, Б. Амарантов нарын зэрэг нэр цуутай жүжигчид төгсчээ.

ЗУРАГ ДЭЭР:

Валерия Балюка, Елены Петунина, Олега Брускова нар төмөр утсан дээр эквилибр тоглох шалгалт өгч байна.

ТАСС-ын гэрэл зураг

НУТГИЙН НАМАР


Малын захад суугаа өвгөд шиг
Манан дундаа хөх уулс нь хөглиж
Хөл тавих зайгүй сувд цацсан адил
Хөрст газрыг бүрхэж хяруу цайрдаг өглөө минь!
Шаргал өвсөнд унасан хярууны чинь ширхэгийг
Шанх гэзгэнд туяарах сувд бишийг мэдлээ ч
Гээсэн эрдэнээ олох гэж дандаа санахаас илүү
Гэрэлт сайхан нутгаа дагтан санаж явдаг би
Гүвээ үл үзэгдэх талын цэнхэр хаяанд
Гүн нуурын тогоруу мэт хадланчны майхан

цэнхэртээд
Гүдэс цайлган түмэн нь талаар дүүрэн жаргалыг
Гужир чийрэг гарынхаа агаар олсон өдрүүд минь!
Урьд шөнийн хяруутай талд бууж хоносон
Уяхан намрын салхи дээлээр оролдон
Унага тамгалах найран дээр сэтгэл хүртэл халж
Уяран хатуужин дуулсан уртын дууны шөнүүд минь!
Зөөлөн хайлган зүрхээрээ хорвоод өргөх дүү минь
Зөөхий шаргал намар талдаа л сонссон дуунаас
эхтэй
Найрын дуунаас тасарсан ая мэт цайлган үр чинь
Найраг шүлгийн мөрүүдээ цинийхээ өмнөөс бичдэгээ
Зүрх үл мартаж хөдөөний минь намар
Зүүд эс өнжин сэтгэл дунд шаргалтана
Өвөл эс өнжин шувууд буцах цагаар
Өргөөнд эс тогтож сэтгэл минь нутагтаа харина.

Д. ЦООДОЛ

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д. ТОВУУ



Хадлангийн талбайд

Б. ЛУАГВА-ийн өсөөк
сүлдээр зураг